



“АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ”
ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ Б.ГҮРСОРОНЗОН
ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ**

Засгийн газрын XIII байр, Чингисийн өргөн чөлөө 11,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14251
Утас: (976-51) 26 31 79, Факс: (976-11) 31 23 15,
Цахим шуудан: info@mrtд.gov.mn,
Цахим хуудас: www.mrtд.gov.mn

2023.11.27 № 03/5609

танай _____-ны № _____-т

Хүсэлт хүргүүлэх тухай

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны А/100 тушаалаар “Зам, тээврийн салбарын чиглэлээр суралцагчдад сургалтын тэтгэлэг олгох журам” батлагдсаны дагуу сонгон шалгаруулалтыг зарлаж, тэтгэлгийг авах эрх үүссэн 100 хүртэлх оюутанд жил бүр 2.000.000 (хоёр сая) төгрөгийг буцалтгүй тусламж хэлбэрээр тус бүр олгохоор болсон.

Тус тэтгэлгийн сонгон шалгаруулалтад тэнцсэн автотээврийн чиглэлээр суралцаж буй 10 оюутныг “Зам, тээврийн салбарын чиглэлээр суралцагчдад сургалтын тэтгэлэг олгох журам”-ын 3.4 дэх заалтын дагуу санхүүжүүлэх асуудлыг шийдвэрлэн хамтран ажиллахыг хүсье.

Сонгон шалгаруулалтад тэнцсэн сурагчдын нэрс болон Зам, тээврийн салбарын тэтгэлгээр суралцагчтай байгуулах гэрээг хавсаргав.

Хавсралт ³ хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА С.БАТБОЛД



Боловсруулсан: 

Хянасан:

Хувь: 2

Огноо: 2023.11.27

№	Овог	Нэр
1	Ядмаа	Төмөрбаатар
2	Наранчулуун	Хашчулуун
3	Өнөрбуян	Сансармаа
4	Мягмаржав	Агиймаа
5	Батсайхан	Амарзаяа
6	Сэдэд	Бадрал
7	Дамдиндорж	Бодьсайхан
8	Адилбиш	Мөнхсүх
9	Батсайхан	Амарзаяа
10	Ганчулуун	Гантогтох

**ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН ТЭТГЭЛЭГЭЭР
СУРАЛЦАГЧТАЙ БАЙГУУЛАХ ГЭРЭЭ**

2023 оны дүгээр сарын

№ ...

Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү гэрээний зорилго нь зам, тээврийн салбарын мэргэжлээр суралцагчийг нэмэгдүүлэх, салбарын хүний нөөцийг бэлтгэхэд Зам, тээврийн хөгжлийн яамны Сургалтын асуудал хариуцсан зөвлөл (цаашид "Зөвлөл" гэх), Авто тээврийн үндэсний төв ТӨҮГ (цаашид "АТҮТ ТӨҮГ" гэх) болон зам, тээврийн салбарын тэтгэлгээр суралцах суралцагчийн (цаашид "суралцагч" гэх) тэтгэлэгт хамрагдахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Суралцагч тэтгэлэгт хамрагдаж, тасралтгүй амжилттай суралцсан тохиолдолд зам, тээврийн салбарт ажиллаж, зам, тээврийн салбарыг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулна.

Хоёр. Зөвлөлийн хүлээх эрх, үүрэг

- 2.1 Суралцагчийн суралцах хугацаанд голч оноо буурсан эсэх, дараа жилийн тэтгэлэгийн шаардлага хангаж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллана.
- 2.2 Суралцагчийн талаарх холбогдох мэдээллийг лавлах, шаардах эрхтэй.

Гурав. АТҮТ ТӨҮГ-ийн эрх, үүрэг

- 3.1 Суралцагчийн нэр бүхий дансанд нь тэтгэлэгийг шилжүүлнэ.
- 3.2 Үйлдвэрлэлийн дадлага хийхэд дэмжлэг үзүүлнэ.

Дөрөв. Суралцагчийн хүлээх эрх, үүрэг, хариуцлага

- 4.1 Суралцагч амжилттай суралцаж шаардлага хангасан тохиолдолд тэтгэлэгт хамрагдана.
- 4.2 Зам, тээврийн салбарын чиглэлээр суралцагчдад сургалтын тэтгэлэг олгох журмыг мөрдөж, идэвх чармайлт гарган суралцана.
- 4.3 Суралцагч нь сургуулиа амжилттай төгсөөд зам, тээврийн салбарт ажиллана.

Тав. Гэрээний хугацаа

- 5.1 Энэхүү гэрээ нь гарын үсэг зурсан өдрөөс эхлэн 1 жилийн хугацаанд хүчинтэй байна.
- 5.2 Энэхүү гэрээг 3 хувь үйлдэж ЗТХЯ (зөвлөл), АТҮТ ТӨҮГ болон суралцагч, тус бүр гэрээний хугацааг дуустал хадгална.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Зам, тээврийн хөгжлийн яамыг

Суралцагч:

төлөөлж:

.....

.....

Авто тээврийн үндэсний төв ТӨҮГ
төлөөлж:

.....

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот,

Чингисийн өргөн чөлөө -11,

Засгийн газрын 13 байр

Утас: 62-263179

Факс: 11-312315

Цахим шуудангийн хаяг:

info@mrttd.gov.mn